



# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 01 сарын 06 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

## ХОГ ХАЯГДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Хог хаягдлын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.2 дахь хэсгийн “Байгаль орчны” гэсний өмнө “Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 1.5-д заасны дагуу” гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.**Хог хаягдлын тухай хуулийн 37 дугаар зүйлийн дараах хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

### **1/37 дугаар зүйлийн 37.6 дахь хэсэг:**

“37.6.Хуульд заасан нөхцөл, шаардлагыг зөрчсөн тохиолдолд Зөвшөөрлийн тухай хуульд заасан журмын дагуу зөвшөөрлийг түдгэлзүүлнэ.”

### **2/37 дугаар зүйлийн 37.8 дахь хэсэг:**

“37.8.Зөвшөөрлийн тухай хуулийн 6.2 дугаар зүйлд заасан журмын дагуу зөвшөөрлийг хүчингүй болгоно:”

**3 дугаар зүйл.**Хог хаягдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалтын “аюултай хог хаягдлыг тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах, экспортлох үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагад зөвшөөрөл” гэснийг “Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 1.5-д заасан зөвшөөрлийг аж ахуйн нэгж, байгууллагад” гэж, 9 дүгээр зүйлийн 9.3.2 дахь заалтын “энгийн хог хаягдлын төвлөрсөн цэгийн болон хог хаягдлыг сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаа эрхлэх” гэснийг “Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 1.22-т заасан” гэж, мөн зүйлийн 9.3.3 дахь заалтын “зөвшөөрөл олгох журмыг батлах” гэснийг “зөвшөөрлийг Зөвшөөрлийн тухай хуульд заасан журмын дагуу олгох” гэж, 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсгийн “37.1.2-т” гэснийг “37.1.1-д” гэж, мөн зүйлийн 37.7 дахь хэсгийн “дахин” гэснийг “Зөвшөөрлийн тухай хуулийн 6.1 дүгээр зүйлийн 5-д заасны дагуу” гэж, 38 дугаар зүйлийн 38.3 дахь хэсгийн “зөвшөөрөл авах тухай өргөдөлд” гэснийг “Зөвшөөрлийн тухай хуулийн 5.1 дүгээр зүйлд зааснаас гадна” гэж тус тус өөрчилсүгэй.

**4 дүгээр зүйл.**Хог хаягдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

**5 дугаар зүйл.**Энэ хуулийг 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР